



**НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 01 сарын 03 өдөр

Дугаар 8/01

Улаанбаатар хот

Ёс зүйн хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 хэсэг, 26 дугаар зүйл, Монгол Улсын засгийн газрын 2010 оны Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай 288 дугаар тогтоол, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”, Газрын дүрмийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГазрын Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах байгууллагын ажилтан, албан хаагчдын баримтлах ёс зүйн журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Байгууллагын хэмжээнд Төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, мөрдлөг болгож ажиллахыг Ёс зүйн хороонд даалгасугай.
3. Дээрх дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд баримтлан ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.
4. Ёс зүйн хороог удирдлага, зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж, тайлагнахыг Ёс зүйн хорооны даргад үүрэг болгосугай.

ДАРГА



С.БАТЖАРГАЛ

НБМҮТП ОНӨТҮГазрын даргын
2018 оны 01 дүгээр сарын 02 ны өдрийн
А/21 тоот тушаалын хавсралт



НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ОНӨТҮГАЗРЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байгаа төрийн албан хаагч (цаашид "Төрийн үйлчилгээний албан хаагч" гэх)-ийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, албан үүргээ гүйцэтгэхдээ удирдлага болгох ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс, дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд оршино.
- 1.2. Төрийн үйлчилгээний албан тушаалд орохыг хүсэгч нь албан тушаалд томилогдохын өмнө энэхүү журамтай бүрэн танилцаж, ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргахгүй байх тухай баталгаа гарган төрийн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалуулсан байна.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Энэхүү журамд НБМҮТП ОНӨТҮГазрын ажилтан албан хаагчид хамаарна.

Гурав. Ёс зүйн зарчим

- 3.1. Төрийн үйлчилгээний албан хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан ёс зүйн зарчмыг баримтална:
 - Шударга ёсны зарчим
 - Хууль дээдлэх зарчим
 - Тэгш байдлын зарчим
 - Хариуцлага хүлээх зарчим
 - Олон нийтэд үйлчлэх зарчим
- 3.2. Энэхүү дүрмийн 3.1-д заасан зарчмын хүрээнд төрийн захиргааны албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхдээ удирдлага болгох ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс болон дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тодорхойлно.

Дөрөв. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйлс

6.3.2. Гомдол, мэдээлэлд холбогдох төрийн үйлчилгээний албан хаагч болон түүний харьяалах төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, гомдол, мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдний тайлбар, саналыг сонсох, холбогдох нотолгоо, материал, баримт бичгийг шаардан авах;

6.3.3. Гомдол, мэдээллийг шалгасан тухай дүнг хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхийн саналаар дүгнэлт гаргах бөгөөд энэхүү дүгнэлт нь аливаа албан тушаалтан, улс төрийн хүчний нөлөөлөлд автаагүй, нотлох баримтад үндэслэгдсэн байх;

6.3.4. Ёс зүйн хороо нь төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн зөрчлийн тухай мэдээг хагас болон бүтэн жилээр гаргаж, мөн оны 07 дугаар сар болон дараа оны 01 дүгээр сарын 10-ны дотор гаргаж тайлагнана.

Долоо. Албан хаагчийн хувцаслалт, гадаад төрх байдал

7.1. Албан хаагчид гадаад төрхөөрөө ажил хэрэгч, цэвэрч соёлтой, энгийн даруу хувцаслана.

7.2. Эмэгтэй албан хаагч:

7.2.1. Эмэгтэй албан хаагчид хэт богино банзал, цээж хэсгийг хэт ил задгай гаргасан хувцас өмсөхгүй байх.

7.2.2. Хэт этгээд олон өнгийн тод, олон тооны гоёл чимэглэлийн зүйлс, хувцас, хар өнгийн нарны шил /ажлын цагаар/ зүүхгүй байх

7.3. Эрэгтэй албан хаагч:

7.3.1. Үс богино засалттай, сахал үс ургуулаагүй байх, богино өмд болон биеийн тамирын хослол ажлын цагаар өмсөхгүй байх, бүх албан хаагчид элдэв тод өнгөөр үсээ будах, этгээд байдлаар засуулахгүй байх.

7.3.2. Биеийн ил үзэгдэх хэсэгт шивээсгүй байх

Найм. Ёс зүйн хэм хэмжээг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

8.1. Ёс зүйн хорооны дүгнэлтийг үндэслэн газрын дарга нь албан хаагчид (Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулах тухай шийдвэр гаргана.